

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БИЧИГ

№ 17/457

ШУС, НУС

2016

“МОНГОЛ ТУЛГАТНЫ 100 ЭРХЭМ”: РЕЙТИНГ БИШ, САЙН СЭТГҮҮЛ ЗҮЙ ТЭСЧ ҮЛДДЭГ

Д.Идэржаргал*

* МУИС-ийн Шинжлэх ухааны сургуулийн Нийгмийн ухааны салбарын Сэтгүүл зүй, олон нийтийн харилцааны тэнхимийн багш, сэтгүүл зүйн магистр, докторант

Түлхүүр үг: «Монгол тулгатны 100 эрхэм», телевизийн нэвтрүүлэг, сэтгүүлчийн ёс зүй, мэргэжлийн ёс зүйн алдаа, рейтинг

Монголын телевизийн хамгийн алдартай нэвтрүүлгүүдийн нэг бол “Монгол тулгатны 100 эрхэм” яах аргагүй мөн. “Ного entertainment” студитэй хамтарсан тус нэвтрүүлгийн баг анхны дугаараа 2011 онд олон нийтэд хүргэснээс хойш нийт 50 дугаар гаргажээ.

Ардын уран зохиолч, Соёлын гавьяат зүтгэлтэн, төрийн шагналт яруу найрагч Б.Лхагвасүрэн гуай нэвтрүүлгийнхээ нэр хүндийн тухай “Монголчууд манай нэвтрүүлгийг гэрийн даалгавар шигээ үздэг” хэмээн хэвлэлд ярьж байв. Үнэхээр ч монголчууд энэ 50 дугаарыг үүрэгт ажил аятай яс сууж үзсэн. Зохиогчид нь өнгөрсөн дөрөвдүгээр сард нэвтрүүлгийг түр зогсоосон хэдий ч телевизүүд одоо хүртэл өмнөх дугааруудыг давтан гаргасаар байгаа нь хэр чанартай, хэр эрэлттэй бүтээл болсныг харуулна.

Санаачлагчид Монголын хамгийн НӨЛӨӨ БҮХИЙ ЭРХЭМ ХҮМҮҮСИЙГ онцлох учраас нэвтрүүлгээ “Монгол тулгатны 100 эрхэм” хэмээн нэрлэжээ¹. Үнэхээр ч манай улсын хамгийн эрхэм хүндтэй хүмүүс оролцдог учраас энэ уран бүтээлийн нөлөө телевизийн бусад нэвтрүүлэгтэй харьцуулагдашгүй. Нөгөө талаас зочныг сэтгэлийн гүнээ уудалтал яриулах хөтлөгчдийн авьяас чадвар, нэвтрүүлгийн эвлүүлэг, сонирхолтой зураг авалтууд, дуу, дүрсний чанар, зураглалын өвөрмөц шийдэл зэрэг нь нэвтрүүлгийг дахин давтагдашгүй болгодог. Их аварга Д.Дагвадорж, УИХ-ын гишүүн асан Х.Баттулга нар нэвтрүүлгийн үеэр уйлж, Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж оросоор шүлэг уншиж, Ардын жүжигчин Г.Хайдав гуайн оролцсон нэвтрүүлгийн дараа түүнийг орон сууцтай болгох хөдөлгөөн өрнөж, МАХН-ын дарга Н.Энхбаярын дугаар бүхэлдээ гээд нэрлээд баршгүй олон дуулиан шуугианыг нэвтрүүлэг бий болгож чадсан юм.

Харамсалтай нь телевизийн сэтгүүл зүйн бүтээлүүдээс чансаа илт

илүүрхсэн “Монгол тулгатны 100 эрхэм”-д нэг чухал зүйл дутагдаж байна. Энэ бол ёс зүй.

Нэвтрүүлгийн олон дугаарт хувийн нууц задлах, хувийн амьдралыг дэлгэх, садар самуун сурталчлах, хочлох, гутаан доромжлох зэрэг сэтгүүлчийн ёс зүйн ноцтой алдаа давтагдаж байна. Эдгээр алдаа гарснаар “20, 21-р зууны эхэн үед Монголын түүхийг бичилцсэн нэр алдартай хүмүүсийн амьдралын түүхийг залуу үеийнхэндээ хэлж, ойлгуулан үлдээх зорилготой”² нэвтрүүлэг нийгэмд буруу хандлага, ойлголтыг түгээн дэлгэрүүлэх зорилготой юм шиг ойлгогдож байна.

“Монгол тулгатны 100 эрхэм” нэвтрүүлэг мэргэжлийн ёс зүйн алдааг давтаж буй хэсгүүдийг буулган хүргэе.

А. БУСДЫГ ГУТААН ДОРМЖИЛЖ, ХОЧИЛЖ, ХУВИЙН АМЬДРАЛЫГ ДЭЛГЭЖ, САДАР САМУУН СУРТАЛЧИЛЖ, ХУВИЙН НУУЦАД ХАЛДАН ХУУЛЬ ЗӨРЧСӨН ДУГААР

ТӨРИЙН ШАГНАЛТ, АРДЫН ЖҮЖИГЧИН, НАЙРУУЛАГЧ Б.ЖАМЪЯН-ДАГВЫН ОРОЛЦСОН ДУГААР:

Б.Лхагвасүрэн: Эмэгтэй хүнийг бол аальгүйтэж байсан гэж хэлнэ, эр хүнийг бол самбаганаж байсан гэнэ. Өөрөө залуу цагтаа ер нь хэр самбагануур хүн байсан бэ?

Б.Жамъяндагва: Нэгд, самбаганах гэдгийг их, бага гэж хэмжинэ. Хоёрдугаарт, би их архи уудаг байсан хүн. Архиа хөөцөлдөхөөс авгай хүүхэн хөөцөлдөх нь их ховор байлаа. 16 жил архи уусан.

Б.Лхагвасүрэн: Архи уухаар чинь хайр согтдог юм биш үү? Авгай эзгүйд гарч болох тохиолдол байна шүү дээ.

Хөтлөгч 80 гарсан зочноосоо шууд утгаар хэнтэй явалдаж байсан гээд асуучихав. Зочны хариултаас ийм зүйл болоогүй бөгөөд энэ талаар ярихыг хүсэхгүй байгааг харж болно. Гэсэн ч хөтлөгч дараагийн асуултаараа хувийн амьдралаа дэлгэхийг лавшруулан “шаардаж” байна.

Б.Жамъяндагва: Манай Гончигсумлаа гуайн дэвтэр дээр 200 нэр биччихсэн, миний унтсан хүүхнүүд гээд үзүүлж байсан (инээв). Нээрээ 200 хүрчихсэн.

Б.Лхагвасүрэн: Чимэд гуай нэг өдөр “Би урьд шөнө нойр хүрэхгүй хавьтсан хүүхнүүдээ бичсэн чинь 100 жаахан гаргаад санадаггүй” гэж ярьж байсан шүү. Эд нар бүр алдааг юм шиг байгаа юм.

Хувийн нууцыг дэлгэх алдаа гаргав. Үхсэн хүн өөрийгөө өмөөрч үг хэлэхгүй. Ардын жүжигчин, Урлагийн гавьяат зүтгэлтэн, төрийн шагналт хөгжмийн зохиолч С.Гончигсумлаа гуайн гэр бүл, үр хүүхдүүдэд энэ яриа ямар муухай сэтгэгдэл төрүүлснийг хэмжих аргагүй юм. Нэрт зохиолч, судлаач, яруу найрагч Ч.Чимэд гуайг ч нүүр хийх газаргүй болгоо биз.

Хүний хувийн нууцыг дэлгэх нь ёс зүйн алдаа гэхээсээ гадна “Хувь хүний нууцын тухай хууль” зөрчиж байгаа хэрэг юм³. Хувийн нууц 4 төрлөөс бүрдэх бөгөөд энэ хэсгийн яриа л гэхэд хоёр хүний гэр бүлийн нууц⁴ буюу бусдад задруулбал тухайн хувь хүн, түүний гэр бүлийн гишүүдийн нэр, алдар хүнд, ашиг сонирхолд харшлах мэдээллийг задалж байна.

Б.Лхагвасүрэн: Ажил болохгүй, дурлаж чадаагүй гэж хэлдэг хүмүүсийг

би үзэн яддаг байхгүй юу. Ажлын зав гараагүй, би ерөөсөө дурлаагүй, би ерөөсөө юм сонирхохгүй давхиад л байсан, зав байхгүй гээд л. Баянмөнх аварга нэвтрүүлэгт орохдоо ч “Би бол мөнхөд барилдаад күйкэн мүүкэнтэй уулзахын арга байгаагүй” гэж ярьж байсан.

Б.Жамъяндагва: Дурлал гэдэг чинь өөр; тачаангуй байдал, сонирхол гэдэг чинь бас өөр зүйл шүү дээ.

Б.Лхагвасүрэн: Үгүй тэгвэл аль аль нь байхгүй юу?

Б.Жамъяндагва: Дурлаад нэг л авгайтай суусан даа. Одоо хүртэл тавин хэдэн жил би нэг л авгайтай яваа.

Б.Лхагвасүрэн: Би ганцхан гашуун үнэнийг хэлье. Энэ орчлонд нэг эмээр дууссан эр, нэг эрээр дууссан эм гэж байдаггүй.

Б.Жамъяндагва: Тэр чинь мэдээж шүү дээ.

Б.Лхагвасүрэн: Мэдээж юм бол, юмаа нуугаад байхаар чинь... Эртхэн хэлчихсэн бол би ийм олон асуулт тавихгүй байсан байхгүй юу.

Б.Жамъяндагва: Улсууд сонирхох юмаа сонирхож явж л таараа. Хүнд сонирхогдож явсан бол сонирхогдож явсан л байж таараа. Тэр бол мэдээж шүү дээ.

Хөтлөгч шордсоор байгаад зочныхоо нууцыг яриулахаар боллоо. Хойч үеийнхэндээ сургамж болох зорилготой нэвтрүүлэг маань юу сургаж байгааг уншигч та бодоод үзээрэй. “Энэ орчлонд нэг эмээр дууссан эр, нэг эрээр дууссан эм гэж байдаггүй” гэх үг хичнээн залууст хүн бүр л явалддаг байх нь гэсэн ойлголтыг төрүүлээ бол?

Б.Лхагвасүрэн: Би түрүүн хэлсэн дээ. Шар сэмжлээд үхсэн хүнийх булшаа цоолоод гозойчихсон байсан гэж.

Б.Жамъяндагва: Шар сэмжлээд дараад нь бор өвдөглөнө гэж байдаг гэж байгаа юм.

Б.Лхагвасүрэн: Бор өвдөг гэдэг нь юу юм?

Б.Жамъяндагва: Шар сэмж чинь одоо амаараа жигтэйхэн дуртай болдог. Дараа нь бор өвдөг нь бүр байхгүй болчихдог. Тэгээд шар сэмжний хоёр дахь үе нь эхлэхлээр настай болчихсон хойноо буюу 80-аас дээш насандаа бол ажиллаад эхэлдэг гээд байгаа.

Б.Лхагвасүрэн: Хүүш тийм үү? Тэгвэл Бааст гуай бас эхэлчихсэн юм байна л даа.

Б.Жамъяндагва: Тэхх. Цаадах чинь шар сэмж нь дуусаад, бор өвдөг нь дуусаад, одоо шар сэмжнийхээ хоёр дахь үе рүү орчихсон явж байгаа.

Б.Лхагвасүрэн: Хамгийн оргил үе дээрээ.

Энд садар самууныг нарийвчлан харуулах, сурталчлах алдаа гарчээ. Түүгээр ч зогсохгүй Ардын уран зохиолч, Соёлын гавьяат зүтгэлтэн, зохиолч Б.Баастыг гутаан доромжилж, нэр хүндэд ноцтойгоор халдсан сэтгүүлчийн ёс зүйн алдаа давхардаж байна.

Яриа үргэлжлэх зуур Б.Жамъяндагва, Б.Лхагвасүрэн гуай нар зэрэг зэрэг тамхи татна. Утаагаа нэгэн лүүгээ үлээж, бас бага зэргийн халчихсан байгаа нь харагдана. Энэ бол “Тамхины хяналтын тухай хууль”-ийн⁵ 8.1.1 дэх заалт буюу “тамхи, тамхи ороодог цаас, тамхины шүүр, тамхи орооход хэрэглэгддэг төхөөрөмж,

тамхины бусад дагалдах хэрэгсэл, тамхи үйлдвэрлэгчийн нэр, лого, тамхин бүтээгдэхүүн, түүний брэндийн нэр, барааны тэмдэг, тамхи үйлдвэрлэгчтэй холбоотой өнгө, өнгөний хослол, үг хэллэг, дизайн, зураг, дүрс, үнэр, дуу авиаг ашиглах, алдартай жүжигчин, тамирчин, урлаг, соёлын ажилтан зэрэг олон нийтийн дунд нэр хүнд бүхий хүнийг оролцуулах замаар тамхийг хэвлэл, мэдээллийн хэрэгсэл, кино, хувцасны загвар өмсөх үзүүлбэр, урлаг, спортын тоглолт, уралдаан, тэмцээн, гар утас, бусад шинэ технологи, ханын болон гудамжны самбар, зурагт хуудас, зар чимэглэл, зорчигчийн тийз ашиглах болон бусад биет байдлаар сурталчлахыг хориглох"-ыг ноцтойгоор зөрчиж байгаа явдал юм. Олон нийтийн мэдээллийн хэрэгслээр, тэр дундаа хөтлөгч нь тамхи татдаг моральгүй явдлыг Монголын телевизүүдийн уран бүтээлчид өмнө нь гаргаж байгаагүй.

Б.Жамъяндагва: Би чамд Нямдорж гуайн тухай хачин юм ярих уу? Москвад оюутан байхад архи ууж согтоод Ленинградын "Цагаан шөнө" дээр оччихгүй юу. Тэгээд биеэ үнэлэгч янхан хүүхэнтэй уулзаж л дээ. Тэр тухайгаа бичсэн байгаа юм.

Туяа татсан Цагаан шөнийн сайханд

*Тууз алаг англи архины халуунд
Мөнгө залангаар ян авгай хүзүүдэж
Мөнх биш ч гэсэн жаргал дунд
ташуурнам*

*Цагаан шөнийн гэрэл дор нүцгэлж
Цайрах бие, өндөг, мээмийг нь
базлахад*

*Харанхуйн дунд харийн охин мөнгөн
дор амьсгаадна гэж. Үгүй мөн муухай
хэлж байгаа юм шүү. Аюултай хэлж
байгаа биз?*

«

***Нэвтрүүлгийн олон дугаарт
хувийн нууц задлах, хувийн
амьдралыг дэлгэх, садар самуун
сурталчлах, хочлох, гутаан
доромжлох зэрэг сэтгүүлчийн ёс
зүйн ноцтой алдаа давтагдаж
байна. Энэ нь "20, 21-р зууны эхэн
үед Монголын түүхийг бичилцсэн
нэр алдартай хүмүүсийн
амьдралын түүхийг залуу
үеийнхэнд ойлгуулан үлдээх
зорилготой" нэвтрүүлэг нийгэмд
буруу ойлголтыг дэлгэрүүлэх
зорилготой мэт ойлгогдож байна***

»

Магтан матна гэгчээр Төрийн соёрхолт яруу найрагч Н.Нямдоржийн хувийн нууцыг мөн л дэлгэж, нэр хүндэд нь халдаж байна. Анхааруштай нэг зүйл нь эдгээр яриаг зочин олон нийтийн мэдээллийн хэрэгслээр цацахыг хүсээгүйг тэдний ярианаас харж болно. Хэдийгээр хөтлөгч Б.Лхагвасүрэн ийм ёс зүйгүй яриаг хадгалж авахыг шаардсан байлаа ч нэвтрүүлгийн багийнхан хасалгүй

Б.Лхагвасүрэн:

Энийг бичих ёстой шүү. Бичсэн үү? (зураглаачид хандан хэлэв)

Б.Жамъяндагва:

Хэрэггүй ээ.

Б.Лхагвасүрэн:

Бичих хэрэгтэй. Заавал бичээрэй. Тэр үеийн хамгийн сайхан хүүхэн гэж ямар хүнийг харж байв? Гоо сайхнаас нүд буруулдаг эрхүн гэж байхгүй.

үлдээсэн нь бас л хариуцлагагүй, ёс зүйгүй хандсаных юм.

Энэ мэтчилэн садар самуун, эр хүн бүр эхнэрээ хуурдаг гэдэг үзлийг сурталчилсан яриа 10 гаруй минут үргэлжилнэ.

Б.Жамъяндагва: Бүдүүн Дамидаа “Муу золиг чинь үүр цайхын үед л босоод ирэх юм. Шээчихээр байхгүй болчих юм” гэж ярьдаг шүү.

Б.Лхагвасүрэн: Кино үйлдвэрийн үүдэнд суучихаад орсон хүн болгонд “Гозойж л байвал дүрээд бай” гэхчхэн суудагсан. Билэгийн Дамдинсүрэн гуай эр хүн шүү. Зодолсон ч, яасан ч хүүхнүүдтэй хавьтаж байгаа нь гайхалтай.

Төрийн хошой шагналт, Ардын жүжигчин Б. Дамдинсүрэн гуайн нэр хүндийг мөн л гутаан доромжилж, хувийн нууцыг нь дэлгэжээ. Бүр энэ ярианаас Б.Дамдинсүрэн садар самууныг сурталчлагч байж гэж дүгнэж болохоор. “Б.Дамдинсүрэн гуай хүүхнүүдтэй хавьтаж байгаа нь гайхалтай” гэх үгээс Б.Лхагвасүрэн гуай тэр үед нь хажууд нь байж гэсэн ойлголт бас төрж байна.

Б.Лхагвасүрэн: ... Тэгээд салгалаад Мөөөөг гэрт нь хүргэж өгсөн чинь авгай нь хаалгаа тайлж өгчихөөд өөрийнхөө өрөөнд ороод хаалгаа түгжчихсэн. “Далайцэцэг ээ” гээд хэд хэд дуудаад гарч ирдэггүй. “Солонгосын тагнуул аа” ч гэж дуудлаа. Тэгсэн “Далайцэцэг ээ пизда” гээд дуудсан гараад ирчихсэн.

Б.Жамъяндагва: Яагаад Солонгосын тагнуул гэж?

Б.Лхагвасүрэн: Солонгос хүүхэн байхгүй юу. Яагаад солонгос хүүхэнтэй суусан юм та гэхээр Мөөөө

“Яахав дээ Чойдог пиздагийнд очиж бардаклаж байгаад авчихгүй юу” гэж. Ай даа бичээд л байгаарай. Ердөө хэрэггүй юм байхгүй шүү. Хараар нь хадгалчихна. Бид хоёр хорвоод дахиж ингэж ярилцаж суугаа ч юу. Ёстой хар материал байсан ч бичээд ав. (зураглаачид хандан хэлэв). Өөрт чинь дурлаж байсан хүн байна уу? Энийг л хүмүүс их нуух юм. Надад дурлаж байсан гээд зоригтой хэлчих хүн байна уу?

Телевизийн дэлгэц тамхины утаанд баар паб гэлтэй цэнхэртэн харагдана. Зохиолч, хөтлөгч хоёр ам халж ярилцаар л. Монгол Улсын Төрийн дууллыг зохиолцсон Л.Мөрдөрж гуайн хувийн амьдралыг дэлгэв. Ёс зүйн ийм ноцтой алдаа гаргаад зогсохгүй “п”-ээр эхэлсэн хараалын үгсийг хэд хэд хэлээд амжив.

Сэтгүүлчийн ёс зүйн олон ноцтой алдааг гаргасан, садар самууны л тухай өгүүлэх энэ яриаг Б.Лхагвасүрэн гуай маш хэрэгтэй зүйл хэмээн хэлж байгаа нь гайхал төрүүлнэ.

В. “ГЭР БҮЛИЙН ХАРИЛЦАА СЕКС ДЭЭР ТОГТДОГ”

МОНГОЛЫН УЛС ТӨРИЙН НЭРТ ЗҮТГЭЛТЭН Ц.ЛООХУУЗИЙН ОРОЛЦСОН ДУГААР:

П.Анужин: Та амьдралдаа их хэлмэгдсэн юм байж. Тэгвэл гэр бүлийн хүрээнд хэлмэгдэл гэж байж болох уу?

Ц.Лоохууз: Болно. Гэр бүлийн хүрээнд таарч тохирдоггүй, нэг нь нэгнийгээ хүчирхийлдэг, зоддог нүддээ явдал бол байна. Энэ бол буруу. Тэгээд секс амьдрал гэж байна. Энэ нь таарах, таарахгүй гэж байдаг. Нэг нь

нэгэндээ гологдох гэж байдаг. Тийм учраас өөр хүнийг хайдаг ийм явдал бол хүн төрөлхтний бүх түүхийн туршид бий. Нууц эрхтэний нууц ажил гэж бий. Энийг үгүйсгэх юм байхгүй. Сексийн харилцаа тохироогүй бол тэр амьдрал амьдрал болдоггүй. Энийг ярих дургүй, хэлэх дургүй, тэгээд дандаа нууц. Гэтэл энэ нууц ажил дээр гэр бүл зохиогддог. Бодитоор л үзэх хэрэгтэй.

Ц.Лоохууз: Би амьдралдаа гуравхан эмэгтэйг харсан. Тэдний амт шимийг би амталсан. Нэг нь Лхагважав, надаас гурав ахмад. Анхны нөхрөө алуулсан хүүхэн. Хоёр дахь нь Оросын сургуульд сурч байхдаа үзсэн, туршсан орос хүүхэн. Орос гэж польш хүүхэн. Гурван жил түүнтэй нөхөрлөсөн. ... (эхнэртэйгээ хэрхэн гэрлэсэн тухай яриа өрнөө).

Ө дгөө 93 настай Ц.Лоохууз гуайн ам үнэхээр халсан байлаа. “Та нараас өмнө хэн ч надтай ингэж илэн далангүй ярилцаж байсангүй” гэж хэлж буй дүр төрхөөс нь түүний сэтгэл их хөдөлсөн нь ч харагдана. Гэхдээ энэ эрхэмийн “Гэр бүлийн амьдрал секс дээр л тогтдог” гэх дүгнэлтийг, амьдралдаа гурван эмэгтэйг амталсан тухай түүхийг олон нийтэд зориулах шаардлага байсангүй.

С. “БИЧГИЙН ХЭЛЭНД ТӨГСӨРСӨН Ч ЯРИАНЫ ХЭЛ НЬ ТӨСӨӨРӨВ ҮҮ?”

СОЁЛЫН ГАВЬЯАТ ЗҮТГЭЛТЭН,
СЭТГҮҮЛЧ Д.АМБАСЭЛМАА ГУАЙН
ОРОЛЦСОН ДУГААР:

Б.Лхагвасүрэн: Самбуу эхнэрээ цаашаа хараад зогсохоор нь хормойг нь сөхүүлдэг байсан юм.

Д.Амбасэлмаа: Тийм, ээжийнхээ хормойг сөх гээд, өнөө хүүхэд нь очиж сөхөөд.

Б.Лхагвасүрэн: Самбуу гуай эгдүү нь хүрдэг юмуу хаашаа юм. Авгайгаа араас нь харах гээд хормойг нь сөх гээд. Самбуу гуай бол элдвийн юм байгаагүй байх?

Д.Амбасэлмаа: Гүй цаадах чинь ...

Б.Лхагвасүрэн: Банзал уу?

Д.Амбасэлмаа: МОКС-ийн орлогч үедээ Ардын жүжигчин Цэрэндулам гуай байна идээ.

Б.Лхагвасүрэн: Өө тэрийг чинь янзалсан байх нь.

Д.Амбасэлмаа: Тэрэнтэй хамт хойшоо төлөөлөгчөөр явсан. Тэгсэн Нямаа ажээ бол их тавьтартай хүн л дээ. “Энэ Цэрэндулам манайхаас салахаа байлаа, тэгээд орж ирэхдээ заавал Самбын орон дээр суугаад байх юм” гэж ярьж байж билээ.

Б.Лхагвасүрэн гуай Монголын төр, нийгмийн нэрт зүтгэлтэн агсаны талаар “янзалсан байх нь уу”, “банзал уу” гэж ам уралдуулан асуух нь болиосой гэмээр сэтгэгдэл төрүүлнэ. Д.Амбасэлмаа гуай ч хадам ахынхаа хувийн амьдралыг дэлгэж, Ардын жүжигчин Цэрэндулам агсаны нэр хүндэд халдлаа. Хөтлөгч П.Анужин энэ яриа өрнөх зуур жийрхэж, оруулаад хэрэггүй гэсэн дохиог зураглаачид өгч байгааг бичлэгээс харж болно.

Б.Лхагвасүрэн: Та албаны магтаал хүлээж авдаггүймаа гэхэд амрагийн магтаал хүлээж авсан тухайгаа яриач?

Д.Амбасэлмаа: Лхагвасүрэн минь хачин юм асуух юм. Би Удвал гуайн тухай гэнэт их сонин юм санаанд орсонгоо хэлчих үү? гээд яриу.

Нас намбатай зочин хуучны амрагийн тухай асуултанд илт дургүй байв. Эцэстээ төрийн шагналт, зохиолч С.Удвал агсаны бүтэлгүй хайрын тухай яриагаар асуултыг өнгөрөөхөөр “шийдсэн” юм. Ээжийнх нь бүтэлгүй хайр дурлал, хувийн амьдралыг нь хөндсөн яриа Удвал агсаны үр хүүхдүүдэд таалагдаагүй нь ойлгомжтой.

Амбасэлмаа гуай БНМАУ нийгмээрээ тэмбүү өвчин тусч, түүнтэй улаан тариагаар тэмцэж байх үеийн дурсамжаа ярина. “Залуухан, сайхан хүүхнүүд гоёлын дээлээ өмсөөд морио унаад найр наадам мэт эмнэлэг рүү явцгаадаг. Хоёр ,дөрөв дэх өдөр тариа хийдэг бөгөөд эмнэлгийн хажуугаар өнгөрөхөд аймшигтай эвгүй үнэр үнэртэнэ. Эмнэлгийн цонхоор сонирхоод харахаар эмэгтэйчүүдийг үзэхдээ орон дээр алцайлгаж хэвтүүлээд яр гарсан хэсэг дээр нь тамга дарж байгаа мэт эм түрхэж өгч байсан” гэж яриу.

Б. Лхагвасүрэн гуай, Д.Амбасэлмаа гуай хоёр хоёулаа л бичгийн хэлэнд төгсөрсөн хүмүүс. Үүний хэрээр ярианы хэл нь ч цэгцэрсэн байх учиртай. Харин тус дугаарт энэ мэт гоо зүйгүй дүрслэл, асуултууд олон тараалдсан нь зохимжгүй.

Д. АВГАЙ БА СОНИРХОЛ

МОНГОЛ УЛСЫН ХӨДӨЛМӨРИЙН БААТАР, ТӨРИЙН ШАГНАЛТ, АРДЫН ЖҮЖИГЧИН, ХӨГЖМИЙН ЗОХИОЛЧ Д.ЛУВСАНШАРАВ ГУАЙН ОРОЛЦСОН ДУГААР:

Б.Лхагвасүрэн: “Би чамд хайртай” дууг Явуу багш хэнд зориулж бичсэн

юм, хөгжмийг нь та хэнд зориулж бичсэн юм?

Д.Лувсаншарав: 1954 онд би гавьяат жүжигчин цол авчихсан, гэрлэчихсэн, хүүхэдтэй, уран бүтээл маань олон нийтэд тарчихсан байсан. Хүүхэд, авгайгаа санаад л бичсэн.

Б.Лхагвасүрэн: Хүнд зориулаагүй юу?

Д.Лувсаншарав: Хүнд зориулаагүй.

Б.Лхагвасүрэн: Үнэн биз ?

Д.Лувсаншарав: Авгай хүүхэддээ л зориулсан бүтээл.

Б.Лхагвасүрэн: Явуу багш хэнд зориулсан юм?

Д.Лувсаншарав: Уг нь бол өөр л зориулалттай л даа. Минийх ч өөр зориулалттай.

Б.Лхагвасүрэн: За тэгвэл хэлэхгүй юм байна. Хүний нууц гээд.

Д.Лувсаншарав: Сонирхол гэдэг чинь өөр. Авгай бол яахав хүний хань. Бас өөр юм сонирхох, харах, бодох юм байна.

Б.Лхагвасүрэн: Ер нь амьдрал өөрөө ийм юм биш үү?

Зочдын залуу наснаа дурссан яриа бүрт амьдралыг авгай болон сонирхол гэсэн хэсгүүдэд хувааж байв. Энэ удаа ч мөн адил. Үзэгчид эндээс эрчүүд, ялангуяа Монголын эрхэм эр хүн бүр эхнэрийнхээ ар талд явдалтай байдаг юм байна гэж дүгнэж болохоор.

РЕЙТИНГ БИШ, САЙН СЭТГҮҮЛ ЗҮЙ ТЭСЧ ҮЛДДЭГ

Эдгээр баримтууд хөтлөгч яагаад зочдоор садар самуун сурталчилсан түүх, залуу үеийн амрагийн явдлыг нь яриулахыг оролддог вэ? Зөвхөн өөрийнх ч биш бусад алдар хүндтэй хүмүүсийнхийг ч зочноос асуудаг юм бол? гэж эргэцүүлэхэд хүргэв. “Монгол

тулгатны 100 эрхэм” нэвтрүүлэгт оролцсон улс төрчдөөс бусад зочдоос энэ төрлийн асуулт асуужээ.

Уран бүтээлийн багийнхны албан ёсны вэб хуудсанд “Монгол тулгатны 100 эрхэм”-ийн зорилгыг тодорхойлохдоо⁶ “20-р зууны сүүлчээр Монголын түүхэнд салбар салбартаа амжилт үзүүлж чадсан эрхэм хүмүүсийн намтар түүхийг залуу үеийнхэнд сурталчлан таниулах, тэдгээр хүмүүсээс үлгэр жишээ авахуулах, сургамж, сургаалийг нь ирээдүй үедээ өвлүүлж, үлдээхэд оршино” гэжээ.

- Олноо хүндлэгдсэн зочдоосоо хормойн явдлыг нь асууж, бусдынхыг ч яриулж, хөтлөгч өөрөө ч ярьж, эцэст нь “нууц явдалгүй, нууц амраггүй амьдрал байдаггүй” гэсэн дүгнэлтийг тодоос тод, давтан давтан хийх нь уран бүтээлийн эрхэм зорилготой нийцэх үү?

- Гэрээт найман телевизийн сувгаар цацагддаг, үзэгч олонтой нэвтрүүлэгтээ увиагүй, ам халсан яриаг багтаах нь ёс зүйд нийцэх үү?

- Гэр бүл салалтын томоохон шалтгаан болж буй хууралт, мэхлэлтийг амьдралын гашуун үнэн гэж тунхаглах, сурталчлах нь залуу хойч сайн нөлөө үзүүлэх үү?

Зөв, бурууг шүүх чадвартай хэн бүхэн эдгээр асуултуудад үгүй гэж хариулна. “Монгол тулгатны 100 эрхэм”-ийн зочид Монгол Улсын эрхэмээс эрхэм зүтгэлтнүүд тул нийгэмд нөлөөлөх нь асар хүчтэйг дээр өгүүлсэн. Хэдий тийм ч рейтинг биш сайн сэтгүүл зүй л тэсч үлддэгийг санах хэрэгтэй. Хичнээн алдар хүндтэй эрхэм хүмүүсийг оролцуулсан ч ор хөнжлийн явдал ярьсаар байвал

“Монгол тулгатны 100 эрхэм” “Монгол тулгатны 100 ичиг” ч болж болно. Тиймээс нэвтрүүлгийн хамт олныг нийгэмд буруу үзэл суртал түгээж буй сэтгүүлчийн ёс зүйн алдаанууд, хууль зөрчсөн явдлуудаа давтахгүй байхыг, нэвтрүүлэг зорилгоо хэр биелүүлж буйг эргэн харахыг монгол хүний хувьд чин сэтгэлээсээ хүсч байна.

МҮҮН ч яахав гадных юм, гаж гэдгийг нь мэдэх болсон. Харин “Монгол тулгатны 100 эрхэм” үндэстнийх юм, үргэлж эрхэм, төгс төгөлдөр байх ёстой юм.

Монголчууд “Монгол тулгатны 100 эрхэм”-ийг гэрийн даалгавар шигээ үздэг. Тиймээс энэ уран бүтээлийн хором бүр эрхэм байх ёстой. Эрхэм байхаа байг гэхэд ёс зүйтэй байх ёстой билээ.

Ишлэл

¹ <http://www.ugluu.mn/4723.html>

² <http://www.ugluu.mn/4723.html>

³ Чойсамба Ч., Зулькафиль М. 2004. Сэтгүүлчийн ёс зүй. УБ., х. 130.

⁴ <http://www.legalinfo.mn/law/details/537>

⁵ <http://www.legalinfo.mn/law/details/469>

⁶ <http://mongoltulgatan.mn/p/1>

Ашигласан бүтээлийн жагсаалт

1. Чойсамба Ч., Зулькафиль М. 2004. Сэтгүүлчийн ёс зүй. УБ.

2. “Монголт тулгатны 100 эрхэм” нэвтрүүлэг: Б.Жамъяндагва. <https://www.youtube.com/watch?v=2rCX6-DZbXI> 39:20-49:50 минут хүртэл

3. “Монголт тулгатны 100 эрхэм” нэвтрүүлэг: Ц.Лоохууз <https://www.youtube.com/watch?v=biMuCcw4DB4> 1:07:00-1:12:20 минут хүртэл

4. “Монголт тулгатны 100 эрхэм” нэвтрүүлэг: Д.Амбасэлмаа <https://www.youtube.com/watch?v=gnYfVQe8wco> 29:25-30:21 минут хүртэл

5. “Монголт тулгатны 100 эрхэм”
нэвтрүүлэг: Д.Лувсаншарав
<https://www.youtube.com/watch?v=-jpUihvXgFI> 20:25-22:56 минут хүртэл

Abstract

In this article, I criticized journalists' ethical issues in Mongolian most famous TV program, “Mongol tulgatny 100 erkhem”, which is a personality profile. The program

team invites well-reputed Mongolians who highly contributed in the Mongolian history of the 20th and 21st centuries as a guest and talk over about their life and views on their profession and other wide range of topics. I considered the journalists' ethical lapses during some series. Several professional ethical lapses were repeated during the program, particularly, disclosing private secret and others private life, promoting adultery, dubbing and defaming someone.